



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн нөөцийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/2/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2021 он	Газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342315 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Энхтөр Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	3
3. Аудитын тайлан.....	4
3.1. Ерөнхий зүйл.....	4
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	4
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	4
3.4. Материаллаг байдал	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	6
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	7
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
3.9. Аудитын илрүүлэлт.....	7
Залруулсан алдаа.....	7
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	7
Аудитын зөвлөмж.....	9
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	9
4. Менежментийн захидал	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	11

1.Төрийн аудитын санал, дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Аймгийн нөөцийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг С.Мөнхсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд авлага өглөг, гэрээ хэлэлцээр, цалин, эд хөрөнгийн тооллого, зориулалт бусаар зарцуулсан зэрэг төсөв хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж дахин давтахгүй байх талаар албан шаардлага бичиж менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 26-наас 2021 оны 03 дүгээр сарын 02-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн нөөцийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Аймгийн нөөцийн газар нь өөрийн материаллаг баазыг бэхжүүлсний үндсэн дээр Баяд үүлдрийн хонь, аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, эрчимжсэн мал аж ахуй эрхлэн хөгжүүлэх, цаг үеийн онцгой байдал, гамшгийн үед хэрэгцээтэй үед хэрэгцээтэй газруудад түгээх, нөхөн бэлтгэх, үйлчлэхэд оршино.” гэсэн зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Сангийн сайдын тушаал
- Холбогдох тогтоол шийдвэр, журам

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймгийн нөөцийн газрын 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Аймгийн нөөцийн газар нь бодлогын бичиг баримтгүй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй авлага өглөг, жилийн эцсийн тооллого бүртгэл хийгээгүй, санхүүгийн тайланд цалин хөлс дутуу тусгасан алдаа зөрчил илрээд байна.

Орхон аймгийн “Далайван аудит” ХХК 2020 онд Аймгийн нөөцийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 478914 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 16002.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 1832.98 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

Өгсөн 16002.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1832.98 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2020 оны шилэн дансанд дотоод аудит хийгээгүй. Шилэн дансанд мэдээлээгүй 5 зөрчил байгааг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг 150351.07 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3007.02 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган аймгийн Нөөцийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **81523.6** мянган төгрөгөөр буюу **9.1** хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн **дансны элэгдэл, өр төлбөр, үндсэн хөрөнгийн** данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	329302	22116.94	307185
Авлага	29503977	44057887.95	-14553910
Урьдчилгаа			
Бараа материал	235207270.93	172897061.00	62310209
Үндсэн хөрөнгө	665329885.00	665329885.00	0
Нийт хөрөнгө	742114830.76	660591197.77	81523632
Өр төлбөр	128216743	122632185.7	5584557
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	613898089.74	537959014.07	75939075
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	742114832.76	660591199.77	81523632

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 22.1 мянган төгрөг болж 307.2 мянган төгрөгөөр нь Нийгмийн даатгал хэлтэс, Татварын хэлтсийн өрийг дарсан шалтгаалжээ. Энэ нь мөнгөн хөрөнгө буурснаар ажилчдын нийгмийн даатгал, ХХОАТ төлөх чадвар буусан байна.

Авлага дансны үлдэгдэл 44057.8 мянган төгрөг болж -14553.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд өвсний авлага нэмэгдсэн шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2017-2020 онуудад үүссэн, он удаан жил болсон 22415.9 мянган төгрөгийн байгууллага, хувь хүнээс авах авлага байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 22415.9 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 172897.06 мянган төгрөг болж 62310.2 мянган төгрөгөөр буурсан нь суманд үнэгүй өвс тараасан, зүй бус хорогдол гарсан шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй. Хандив тусламжаар 44954.0 мянган төгрөгийн өвсийг орлогод бүртгэж авсан байна.

Оны эцэст бараа материал, үндсэн хөрөнгө худалдан авалт хийгээгүй. Худалдан авалт хийх санхүүжилтгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 665329.8 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдэлтэй нийлж байна. Худалдан авалт болон акталж хассан эд хөрөнгө байхгүй шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 122632.2 мянган төгрөг болж 5584.5 мянган төгрөгөөр буурсан нь Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтсийн 2017-2020 оны өрийг барагдуулсан шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр нь мал хамгаалах сангаас үүссэн 83225.7 мянган төгрөгийн өр байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2017-2020 онуудын өр төлбөртэй боловч барьцаа хөрөнгө байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 537959.01 мянган төгрөг болж 75939.07 мянган төгрөгөөр буурсан нь авлагаас шалтгаалжээ. Энэ нь байгууллагын үйл ажиллагаа доголдох үр дагавартай байна.

Аймгийн нөөцийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 14908.8 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй нь хивэг худалдаж аваагүй байна. Энэ нь санхүүжилтгүй байсан тул хивэг аваагүй байна.

Нийт зардал өмнөх оноос 57199.3 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэгүй өвс тараасан, зүй бус хорогдол их гарсан зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан эд хөрөнгө, бараа материал байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь өөр өөрийгөө санхүүжүүлэг байгууллага учир төсвийн төсөөлөл хийгдээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 103 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 42 мэдээлэл, 0 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 16002.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн актын биелэлтийг хангаж ажиллаагүй байна. Аудитаар өгсөн 1832.98 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 0 хувьтай байна. Өмнөх жилийн санхүүгийн аудитаар Аймгийн нөөцийн газар нь “татгалзсан” дүгнэлт авсан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
					Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0	0	0
Зөвлөмж	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	0	0	0	0	0	0	0

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 153553.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 153245.7 мянган төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлж, 288.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 153533.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 153245.7 мянган төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.1, 12.2.2, 12.2.3 гэсэн заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

2. Өглөгийг барагдуулж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Могод сум руу Д.Баярмагнай 10 тн хивгийг өгсөн боловч төлбөр нь төлөгдөөгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Гэрээний дүнгээр авлага үүсгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. Зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дах заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

6. Ажилтантай байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дах заалтыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

7. Тушаал шийдвэргүй нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дах заалтыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

8. Өвс хүлээлцсэн авсан, өгсөн акт үйлдээгүйгээс тоо ширхгийн зөрүү үүссэн нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дах заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

9. Анхан шатны баримтгүй нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дах заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

10. Санхүүгийн тайланд бодогдсон цалинг дутуу тусгасан нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

11. Малчинтай байгуулсан гэрээ хүчин төгөлдөр биш байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дах заалтыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

12. Он дамжсан болон тайлант онд үүссэн авлагыг барагдуулаагүй 21641.9 мянган төгрөг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

1.1.1.1 Аудитаар илэрсэн 288.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Булган аймгийн нөөцийн газар нь өвсний нөөцийг үүсгэж өвөлжилт хүндэрсэн малчид болон сумын өвсний фонд нийлүүлдэг байна. Ингэхдээ тушаал шийдвэргүй тооцоо нийлсэн акт үйлдэхгүй хүлээн авч хүлээлгэн өгөх, нөөцөөс гаргаж байгаа өвсийг нярваар дамжуулаагүй нэхэмжлэх, шаардах хуудас бичээгүй анхан шатны баримт үйлдээгүйгээс авлага өглөгийн тооцоо нийлсэн актгүй, дарга өөрийн мэдлээр сум, иргэнд ачуулах, зориулалт бусаар зарцуулах зэргээс авлага өглөг үүссээр байна. Мөн малчин, сахиул ажилд авч ажиллуулахад гэрээ байгуулсан боловч 2 тал гарын үсэг зурж баталгаажуулаагүй, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж хугацаа хоцроолгүй мэдээлж байх, анхаарал татахуйц асуудлаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг сүүлийн 2 жил хийгээгүй байна. Тооллого хийгээгүй үр дагавар нь жилийн эцсийн санхүүгийн тайланд нөлөөлж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл, заалтыг зөрчиж байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Өглөгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2020 оны 09 дүгээр сарын 28-ны малын вакцин 1-р тарилгаар 916 хонинд 2748 тун, 2-р тарилгаар 912 хонинд 2736 тун тарьсан төлбөрийг төлөөгүй өглөгт тусгаагүй байна. /6л*36000=216000 моторын түлш 72000 төгрөг/

1.2. Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

148 мэдээлэл оруулахаас 42 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн

2.2. Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалтыг хэрэгжүүлж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Аймгийн нөөцийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			БУА-2021/2/СТА-ОНӨААН
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймгийн нөөцийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2020 оны 09 дүгээр сарын 28-ны малын вакцин 1-р тарилгаар 916 хонинд 2748 тун, 2-р тарилгаар 912 хонинд 2736 тун тарьсан төлбөрийг төлөөгүй өглөгт тусгаагүй байна. /6л*36000=216000 моторын түлш 72000 төгрөг/	288.0	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
2	148 мэдээлэл оруулахаас 42 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	0	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
3	Бодогдсон цалингаас 308644.82 төгрөгийн цалин санхүүгийн тайланд тусгаагүй	308.6	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
4	Дарга Д.Баярмагнай ажлаас чөлөөлсөн тушаалын ажил хүлээлцсэн хурлын тэмдэглэл, хүлээлцсэн акт байхгүй.	0.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
6	Туслах аж ахуйгаас хөрөнгө гаргах тушаал шийдвэргүй /Аудитын төлбөр/	588.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
8	Аймгийн нөөцийн фондын өвсний хашааны сахиулыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хөдөлмөрийн гэрээ байгуулж Ч.Мөнхсүлдийг 420.0 мянган төгрөгөөр цалинжуулж ажиллуулах гэрээ хийсэн боловч хөдөлмөрийн гэрээ нь баталгаажгаагүй хүчингүй гэрээтэй байна.	0.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
9	Хурган хуц /малын эмч/ 200, задарсан 240, нээлттэй хаалганы өдөрт 50, албан хэрэгцээнд 307 ширхэг буюу 3065000 төгрөгийн өвсийг тушаал шийдвэргүйгээр зарцуулсан.	3065.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
10	2018-2019 онд үүссэн малчнаас авах хурганы авлага 410532, гэрээгээр олгосон хивэгний үнэ 240000, сумдаас авах өвсний авлага 4044500, Д.Баярмагнай даргаас авах авлага 2125500, 2020 онд үүссэн өвсний авлага 10580500, нийгмийн даатгалаас 4240911 төгрөгийг барагдаагүй байна. /цагдаа шүүхээр шалгагдаж байгаа 22415946 төгрөгийн авлагыг хасаж тооцсон болно/	21641.9	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа

11	2020 оны өвөлжилт, хаваржилтад зориулж Булган аймгийн онцгой комиссын 2020 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрээр "Хужрын адаг" ХХК нь аймгийн Нөөцийн газраас 8.5 тн буюу 340 боодол өвсийг 7000 төгрөгөөр үнэлж аваад 2020 оны 10 дугаар сард өвсөөр нь өгөх өвсөө бэлтгэн нийлүүлж чадахгүй бол үнийн дүнгийн 2380.0 мянган төгрөгийг аймгийн Нөөцийн газарт төлөхөөр гэрээ байгуулсан боловч төлөөгүй байна. /өвсний үнийн зөрүү $340 \times 7000 / 5500 = 510.0$ мянган төгрөг/	510.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
12	12.3 тн хивэгнээс 10 тн хивгийг Могод сум руу Д.Баярмагнай дарга өгсөн боловч хивэгний үнэ болох 10 тн $\times 450.0 = 4500.0$ мянган төгрөг дансанд ороогүй байна.	4500.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
13	Урд оны болон тайлант оны нийт өглөгийг барагдуулах	122632.2	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
14	2020 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгээгүй. Тооллогын бүртгэл, тооллого хийсэн хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр байхгүй	0.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Мөнхсайхан М.Элбэгзаяа
ДҮН		153,533.70			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Б.ЭНХТӨР